

БАТЛАВ:

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ
ГАЗРЫН ДАРГА



С.БАЯРЦОГТ



ХУУЛЬ ЗҮЙН САЙД



Д.ДОРЛИГЖАВ



ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Монгол Улсын Засгийн газар шинээр эмхлэн байгуулагдаж байгаатай холбогдуулан Улсын Их Хурлаас 2014 оны 12 дугаар сарын 4-ний өдөр Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний тухай хуулийг шинэчлэн баталсан.

Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний тухай хууль шинэчлэн батлагдсанаар хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого болон гадаадын хөрөнгө оруулалтын бодлого, зохицуулалт, бүртгэлийн асуудал Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах болсон тул Хөрөнгө оруулалтын тухай хуульд заасны дагуу хуучин төрийн захиргааны төв байгууллага /Эдийн засгийн хөгжлийн яам/-ын хэрэгжүүлж байсан чиг үүргийг Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа холбогдох төрийн захиргааны байгууллагад шилжүүлж, нэр томъёог уг хуульд нийцүүлэн өөрчлөх шаардлагатай байна.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2014 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар Эдийн засгийн хөгжлийн яам /хуучин нэрээр/-ыг татан буулгасан бөгөөд "Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч батлах тухай" Улсын Их Хурлын 2014 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн 75 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Хөрөнгө оруулалтын газрыг Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд ажиллуулахаар шийдвэрлэсэн болно.

Иймд дээр дурдсан үндэслэл, шаардлагыг харгалзан Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах нь зүйтэй гэж үзлээ.

Хоёр. Хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөл нь 6 зүйлтэй байх бөгөөд төсөлд дараах асуудлыг тусгана:

1 дүгээр зүйлд "Хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 22.4-т заасан нөхцөл байдал үүссэн эсэхийг нягтлахдаа үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллага болон холбогдох бусад байгууллагаас санал, дүгнэлт авч болно" гэсэн агуулгатай

22.5 дахь хэсэг Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 22 дугаар зүйлд нэмэхээр;

2 дугаар зүйлд Хөрөнгө оруулалтын тухай хуульд заасан төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхийг төрийн захиргааны байгууллагад шилжүүлэхээр зааж өгсөн;

3, 4 дүгээр зүйлд хууль зүйн нэр томъёог хуульд нийцүүлэн өөрчилсөн;

5 дугаар зүйлд хуулийн 8 дугаар зүйл /Эдийн засгийн хөгжлийн яамны хэрэгжүүлж байсан чиг үүрэг/-ийг хүчингүй болсонд тооцохоор;

6 дугаар зүйлд хуулийг хүчин төгөлдөр дагаж мөрдөх хугацааг заана.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засгийн үр дагавар

Хуулийн төсөл батлагдсанаар Хөрөнгө оруулалтын тухай хуулийн хэрэгжилтийг хариуцан зохион байгуулах төрийн захиргааны байгууллага тодорхой болно. Хуулийн төсөлтэй холбогдуулан орон тоо, төсөвт нэмэлт, өөрчлөлт орохгүй.

Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн тухай

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн байх бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн төсөл боловсруулах шаардлагагүй болно.